



46

ГОВЬСУМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 126

Шивээговь сум

Газрын эрхийн төрөл өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны өрөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.8 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.2.1, 20.2.2 дахь заалт, 44 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шивээговь сумын “Бэхт” баг, 21 дүгээр зөрлөгийн баруун урд талд байршилтай 122.5 га газрыг Страто ХХК-д үйлдвэрлэлийн зориулалтаар 5 жилийн хугацаатай ашиглуулсугай.

2. Газар ашиглах эрхийг эрхийн улсын бүртгэлд бүртгэж, гэрээ байгуулан гэрчилгээ олгох, хуулийн дагуу хүлээсэн үүргийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг сумын Газрын даамалд үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн A/186 дугаар захирамжийн холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Ч.СУГАРМАА

